



**МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
ҮНДЭСНИЙ ПАРКЫН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2020 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 19-67

Улаанбаатар хот

*Бартуул
шувуу*

**Виртуал инкубаторын
журмыг шинэчлэн батлах тухай,**

"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.11 дэх заалтууд, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 194-р тогтоол, Мэдээллийн технологийн үндэсний паркийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Мэдээлэл, технологийн үндэсний парк" ТӨААТҮГ-н Виртуал инкубаторын журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Виртуал инкубаторын шинэчлэсэн журмыг 2020 оны 12 дугаар сарын 18-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төслийн удирдлага, хамтын ажиллагааны хэлтсийн дарга /П.Наранцэцэг/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ *AP* ЭЦОГТЭРЭЛ



"Мэдээлэл, технологийн үндэслэлийн Парк"-ын
Захирлын 2020 оны 12 дүгээр сарын 14-ийн
А-67 тоот тушаалаар батлагдсан



ВИРТУАЛ ИНКУБАТОРЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Бизнес эрхлэгч болон бизнес эрхлэхээр зорьж буй ААН, баг, иргэнийг виртуал инкубаторт сонгон шалгаруулж, элсүүлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Виртуал инкубаторын зорилго нь ААН, баг, иргэнийг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран салбар болон салбар дундын үйл ажиллагааг дэмжих, шинэлэг санааг бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, менежментийн цогц үйлчилгээг үзүүлэхэд оршино.
- 1.3 Энэхүү журам нь Мэдээллийн технологийн үндэсний паркийн холбогдох дүрэм, журам, гэрээний салшгүй хэсэг байна.
- 1.4 Элсэгчийг сонгон шалгаруулах, үйл ажиллагаанд нь дэмжлэг туслалцаа үзүүлэхдээ шударга, тэгш, өрсөлдөөний зарчмыг баримтална.
- 1.5 Виртуал инкубаторт элсэгчийн хүсэлтийг тогтмол хүлээн авна.
- 1.6 Виртуал инкубаторын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шалгаруулах ажлын хэсгийг Паркийн захирлын тушаалаар батлана.
- 1.7 Сонгон шалгаруулалт, хяналт-шинжилгээ хийж үнэлгээ өгөх ажлын хэсгийг МТҮП-аас 3 болон 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр томилно
- 1.8 Гишүүд нь бизнес төлөвлөгөөний холбогдох мэдээллийн нууцлалыг чандлан сахих үүрэг хүлээж, Паркийн холбогдох дүрэм журмуудыг мөрдлөг болгон ажиллана.
- 1.9 Виртуал инкубаторт элсэгчдэд дэмжлэг үзүүлэх хугацаа нь нийт 6 сараас 1 жил хүртэл байна.

Хоёр. Виртуал инкубаторт элсэхээр хүсэлт гаргагчдад тавигдах шаардлага, болзол нөхцөл

- 2.1 ААН, баг, иргэн нь виртуал инкубаторт элсэхийн тулд дараах шаардлагуудыг бүрэн хангасан байна. Үүнд :
 - 2.1.1 Хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэгдээд 3 жилээс хэтрээгүй байх /компанийн хувьд/;
 - 2.1.2 Дотоод, гадаадын зах зээлд хэрэгжүүлэх боломж бүхий шинэлэг санаа, шийдэлтэй байх;
 - 2.1.3 Улирал тутамд үнэлэгдэх бололцоо бүхий бизнес төлөвлөгөөтэй байх;
- 2.2 ААН-ийн хувьд 2.1.1, 2.1.2, 2.1.3 дугаар заалтууд хамаарна.
- 2.3 Баг, иргэнд зөвхөн 2.1.2, 2.1.3 дугаар заалтууд хамаарна.
- 2.4 Элсэхийг хүсэгч нь дараах болзол нөхцөлүүдийг бүрэн хүлээн зөвшөөрсний үндсэн дээр сонгон шалгаруулалтанд орно. Үүнд:

- 2.4.1 Мэдээллийн технологийн үндэсний паркаас зохион байгуулдаг үйл ажиллагаанд идэвхи, санаачлагатай оролцох.
- 2.4.2 МТҮП-ын дотоод журам, инкубаторын үйл ажиллагааны журам болон бусад холбогдох дүрэм журмыг даган мөрдөж ажиллахаа зөвшөөрсөн албан бичиг ирүүлсэн байх
- 2.4.3 Сонгон шалгаруулалтын бичиг баримт болон улирал, хагас жил тутмын үнэлгээний тайланг үнэн зөв, бодит мэдээллээр хангах
- 2.4.5 Нийгмийн хариуцлагаа ухамсарлан олон нийтийг хамарсан ажил зохион байгуулах, оролцох, хамтран ажиллах;

Гурав. Элсэлтийн бүртгэл

- 3.1 Хүсэлт гаргагч нь дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ. Үүнд:
- 3.1.1 Виртуал инкубаторт элсэхийг хүссэн өргөдөл;
- 3.1.2 Виртуал инкубаторт дэмжлэг авах хугацаандаа мөрдөж хэрэгжүүлэх, улирал, хагас жил тутам үйл ажиллагаанд нь хяналт тавих бололцоо бүхий бизнес төлөвлөгөө;
- 3.1.3 Хүсэлт гаргагч нь ААН бол улсын бүртгэлийн гэрчилгээ, удирдлагын иргэний үнэмлэх, дипломын хуулбар, аж ахуйн нэгжийн дүрэм;
- 3.1.4 Баг бол багийн бүх гишүүдийн иргэний үнэмлэх, дипломын хуулбар;
- 3.1.5 Иргэн бол иргэний үнэмлэх, дипломын хуулбар;
- 3.1.6 Элсэлтийн хураамж төлсөн баримт;
- 3.2 Хүсэлт гаргагч нь Паркын холбогдох сайтаар орж бүртгүүлэн, дээрх бичиг баримтуудыг virtual_incubator@itpark.mn хаягруу илгээнэ.
- 3.3 Сонгон шалгаруулалтанд тэнцсэн тохиолдолд 3.2-т заалтанд заасан бичиг баримтуудыг нотариатаар баталгаажуулан ажлын 5 хоногийн дотор шуудангаар илгээх эсвэл өөрийн биеэр авчирч өгнө.
- 3.4 3.3-т заасан хугацаанд бичиг баримтуудыг илгээгээгүй эсвэл хуурамчаар бүрдүүлэн өгсөн нь тогтоогдсон тохиолдолд сонгон шалгаруулалтанд оролцуулахгүй
- 3.5 Парк нь виртуал инкубаторт хүсэлт гаргагч зориулан цахим семинарыг зохион байгуулж, бизнес төлөвлөгөө боловсруулахад зөвлөгөө өгч дэмжлэг үзүүлнэ.

Дөрөв. Сонгон шалгаруулалт

- 4.1 Сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг захирлын тушаалаар батлана.
- 4.2 Ажлын хэсэг нь хүсэлт гаргагчийг дараах шалгуур үзүүлэлтүүдийн дагуу дүгнэнэ. Үүнд:
- 4.2.1 Шинэлэг бүтээлч санаа;
- 4.2.2 Хэрэгжүүлэх боломжтой оновчтой шийдэл;
- 4.2.3 Эдийн засгийн үр ашиг;
- 4.2.4 Удирдлагын болон мэргэжлийн ур чадвар;
- 4.2.5 Үйл ажиллагааны төлөвлөгөө
- 4.3 Виртуал инкубаторт элсүүлэх сонгон шалгаруулалтын ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:
- 4.3.1 Цахимаар бичиг баримтыг хүлээн авах;

4.3.2 бичиг баримтын бүрдэл нь энэхүү журамд нийцэж буй эсэхийг нягтлан шалгах;

4.3.3 Сонгон шалгаруурлалтыг цахимаар зохион байгуулна;

4.3.4 Хүсэлт гаргагч нь бизнес төлөвлөгөөгөө сонгон шалгаруулалтын ажлын хэсэгт танилцуулах;

4.3.5 Сонгон шалгаруулалтын дүнг Паркын албан ёсны вэб сайтаар олон нийтэд мэдээлнэ;

4.3.6 Сонгон шалгаруулалтанд тэнцсэн элсэгчийн баримт бичгийн нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хүлээн авч гэрээ байгуулах;

Тав. Виртуал инкубаторын үйлчилгээ, төлбөр

- 5.1 Хавсралтад заасны дагуу багц үйлчилгээг үзүүлнэ.
- 5.2 Парк нь үйлчилгээний багцад нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах, цуцлах эрхийг эдлэнэ. Парк нь энэхүү эрхээ эдэлсний төлөө аливаа үүрэг хариуцлага хүлээхгүй.
- 5.3 Виртуал инкубаторын сонгон шалгаруулалтанд орох элсэлтийн хураамж нь ААН бол 80,000 төгрөг, баг, иргэн бол 50.000 төгрөг байна.

Зургаа. Виртуал инкубаторын элсэгчдийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх

- 6.1 Элсэгчдийн бизнес төлөвлөгөөний явцыг улирал, хагас жил тутамд Мэдээллийн технологийн инкубаторын компаниудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх журмын дагуу үнэлнэ.
- 6.2 Улирлын үнэлгээг холбогдох нэгж, хагас жилийн үнэлгээг ажлын хэсэг тус тус хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгнө.
- 6.3 Холбогдох нэгж, ажлын хэсгийн үнэлэлт, дүгнэлтийг Паркын захиралд танилцуулан, цаашид үйлчилгээ үзүүлэх эсэхийг шийдвэрлүүлнэ.

Долоо. Виртуал инкубаторыг төгсгөх, урамшуулах

- 7.1. Виртуал инкубаторын дэмжлэг авах хугацаа нь дууссан, ажлын хэсгийн үнэлгээгээр төгсгөн гаргах шийдвэр гаргасан тохиолдолд МТҮП-ын захирлын шийдвэрээр төгсгөнө.
- 7.2. Улирал, хагас жилийн үнэлгээнүүдийн дунджийг төгсөлтийн үнэлгээ гэж тооцно.
- 7.3. Виртуал инкубаторын элсэгчийн улирал, хагас жилийн үнэлгээний дундаж нь 90-100 хувь бол "Виртуал инкубаторын шилдэг төгсөгч", 70-89хувь бол "Виртуал инкубаторыг амжилттай төгсөгч" гэрчилгээ тус тус олгоно.
- 7.4 Шилдэг төгсөгчийг бизнес инкубаторт сонгон шалгаруулалтгүйгээр шууд элсүүлнэ.

8.1 Дараах шалтгаануудын аль нэгийг үндэслэл болгон МТҮП-ын захирлын шийдвэрээр элсэгчийг виртуал инкубатораас хасна. Үүнд:

8.1.1 Улирал, хагас жилийн үнэлгээнд ороогүй бол;

8.1.2 Инкубаторын улирлын үнэлгээгээр 50-иас доош хувийн дүн үзүүлсэн бол;

8.1.3 Хагас жилийн үнэлгээгээр 70–аас доош хувийн дүн үзүүлсэн бол;

8.1.4 Ажлын хэсэгт бодит бус хуурамч мэдээлэл бүрдүүлэн өгсөн бол;

8.1.5 Виртуал инкубаторын үйл ажиллагааны журам, хамтын ажиллагааны гэрээг ноцтойгоор зөрчсөн бол;

8.1.6 МТҮП-ын дотоод журмын холбогдох заалтуудыг зөрчсөн бол.

8.2 Виртуал инкубаторын багц үйлчилгээг тухайн иргэн, баг, ААН-д оруулсан хөрөнгө оруулалт гэж үзнэ.

Виртуал инкубаторын үйлчилгээний багц

| Д/д | Багц | Үйлчилгээний нэр | Үзүүлэх үйлчилгээ | Тайлбар | Төлбөр | | |
|-----------------------------|--------|------------------|------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------|------------------------------------------------------------|--------------------------|
| | | | | | Хөнгөлөлттэй үнийн дүн /Инкубатор/ | Үндсэн үнийн дүн /1 сар/ | Үндсэн үнийн дүн /1 жил/ |
| 1 | Багц 1 | Зөвлөх | Бизнесийн зөвлөгөө | Чиглэл тус бүрээр (Сард 4 удаа, 1 удаа 33,500₮) | 0 | 134,000 | 1,608,000 |
| 2 | | | Хууль, эрх зүйн зөвлөгөө | | 0 | 134,000 | 1,608,000 |
| 3 | | | Санхүүгийн зөвлөгөө | | 0 | 134,000 | 1,608,000 |
| 4 | | | Гадаад харилцааны зөвлөгөө | | 0 | 134,000 | 1,608,000 |
| 5 | | | Оюуны өмчийн эрхийн хамгаалалт | | 0 | 134,000 | 1,608,000 |
| 6 | Багц 2 | Хамтын ажиллагаа | Хурлын өрөө | IT HUB ашиглах / сард 2 удаа/ | 0 | 80,000 | 960,000 |
| 7 | | | Танхим /211, 302 тоот өрөө/ | Сард 1 удаа ашиглах / 4 цаг хүртэл/ | 0 | 400,000 | 4,800,000 |
| 8 | | | Лаборатори /210, 303 тоот өрөө/ | сард 1 удаа ашиглах /4 цаг хүртэл/ | 0 | 400,000 | 4,800,000 |
| 9 | Багц 3 | Хүний нөөц | Сургалт | Паркаас инкубаторын компаниудад зориулан зохион байгуулдаг сургалтанд хамрагдах | 0 | 1,700,000 | 20,400,000 |
| 10 | Багц 4 | Маркетинг | Уулзалт, арга хэмжээ /1 удаа/ | Компанийн бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчдэд сурталчлан таниулах, санал хүсэлт авах зорилгоор хурал цуглаан зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлэх | 0 | 200,000 | 800,000 |
| 11 | | | Гадаад дотоодын үзэсгэлэн хамруулах | Жилд 1 удаа | 0 | 2,000,000 | 2,000,000 |
| 12 | | | Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр сурталчилах | Тогтмол | 0 | 210,000 | 2,520,000 |
| 13 | Багц 5 | Урамшуулал | MT-ийн инкубаторт байршуулах | Виртуал инкубаторын үйл ажиллагааны журмын 6.4-р зүйл заалтыг үндэслэл болгоно. | 0 | - | - |
| Нийт үнийн дүн | | | | | 0 | 5,660,000 | 42,712,000 |
| Нийт хөрөнгө оруулалтын дүн | | | | | 0₮ (Инкубатораг компаниас гарах зардал) | 42,712,000₮ (Паркаас үзүүлж буй хөрөнгө оруулалтын дүн) | |